



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖИЖ БУЙ
ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ L3787/3788-MON
ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

ХШҮДАГ/2025/ХШ-03

**УЛААНБААТАР ХОТ
2025 он**

ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ L3787/3788-MON ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын Сайдын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх L3787/3788-MON төслийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор шалгалтыг гүйцэтгэлээ.

Ажлын хэсэгт Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Түмэндэмбэрэл, тус газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг, дотоод аудитор Г.Шүрэндолгор, гэрээт ажилтан О.Пүрэвсүх нар ажиллалаа.

Удирдамжийн дагуу дараах асуудлаар дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэв. Үүнд:

- Төслийн гэрээ, удирдлагын гарын авлагын хэрэгжилт;
- Төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт;
- Бараа, ажил, зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилт;
- Төслийн нэгжийн бүтэц, орон тоо, батлагдсан төсвийн зарцуулалт;
- Зээлийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагын бүртгэл, тайлан тэнцэлд тусгасан байдал.

Төслийн үндсэн мэдээлэл, эрх зүйн зохицуулалт

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх L3787/3788-MON төсөл нь Монгол Улсад тогтвортой, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой, олон улсын санхүүжилттэй томоохон төсөл юм. Энэхүү төслийг Азийн хөгжлийн банк (ADB) болон Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын аялал жуулчлалын салбарыг:

- Байгаль орчныг хамгаалсан;
- Нутгийн иргэдийн оролцоог хангасан;
- Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлсэн;
- Улирлын бус байдлыг багасгасан, тогтвортой хэлбэрээр хөгжүүлэх.

Төслийн гол бүрэлдэхүүн хэсгүүд:

1. Дэд бүтцийн хөгжүүлэлт

- Жуулчны бааз, кемп, үзвэр үйлчилгээний төвүүдийн бүтээн байгуулалт
- Зам, гэрэлтүүлэг, ариун цэврийн байгууламж зэрэг аялал жуулчлалын дэд бүтэц

2. Байгаль орчны хамгаалал

- Эко аялал жуулчлалыг дэмжих
- Хог хаягдлын менежмент, хэт ачаалалтай бүсүүдийн зохицуулалт

3. Орон нутгийн оролцоо ба орлогын боломжууд

- Иргэдийн орлого нэмэгдүүлэх гарааны бизнес, гар урлал, хөтөч бэлтгэх сургалтууд
- Эмэгтэйчүүд, залуусын оролцоог дэмжих

4. Институтийн чадавх бэхжүүлэх

- Аялал жуулчлалын менежментийн байгууллагуудын чадавх сайжруулах
- Судалгаа, мониторингийн систем хөгжүүлэх

- Төслийн санхүүжилт: Азийн хөгжлийн банк (АХБ)
- Зээлийн төрөл дугаар, хугацаа, хүү шимтгэл: Ердийн нөхцөлтэй L3787-MON, хөнгөлөлттэй нөхцөлтэй L3788-MON, 21 жил, жилийн хүү 2 хувь, хүүгийн нэмэгдэл 0.10 хувь байна.
- Нийт төсөв: 38.4 сая ам.доллар, Үүнээс Монгол Улсын Засгийн газар татвараас чөлөөлөх замаар 0.4 сая ам.долларын татвар, хураамжийг санхүүжүүлэх үүрэг хүлээсэн. АХБ-аас 38.0 сая ам.долларын зээл авсан.
- Төслийн хэрэгжих хугацаа: 2021-2025 он

Хүснэгт 1

№	Төслийн эрх зүйн гарын авлагын нэр	Эх сурвалжийн линк, цахим болон цаасан суурьтай баримт
1	Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх L3787/3788-MON төслийн зээлийн гэрээ	Баталгаажсан, цаасан суурьтай
2	Төслийн удирдлагын гарын авлага	https://www.adb.org/sites/default/files/project-documents/50013/50013-002-pam-en.pdf
3	Төслийн холбогдох тайлангууд	https://www.adb.org/projects/50013-002/main
4	АХБ-ны зарцуулалтын гарын авлага	https://www.adb.org/sites/default/files/adb-procurement-policy.pdf

Нэг. Төслийн хэрэгжилтэд хийсэн дотоод хяналт шалгалтын дүн

1.1 Төслийн удирдлагын гарын авлагад төлөвлөсөн 9 арга хэмжээнд зарцуулах 38.4 сая ам.долларын зээлийн хэрэгжилт хүлээгдэж буй гүйцэтгэлээр 32.2 сая ам.долларын ажлыг гэрээлж, 6.2 сая ам.долларын үлдэгдэлтэй байна.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх L3787/3788-MON төслийн 38.0 сая ам.долларын ашиглалтын байдал 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 15.7 сая ам.долларыг банкнаас татаж авсан, 22.3 сая ам.долларыг ашиглаж эхлээгүй байна. Ашиглаж эхлээгүй 22.3 сая ам.долларын зээлээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр гарч буй 16.1 сая ам.долларыг хасахад 6.2 сая ам.долларын зээлийн эх үүсвэр үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2 /мянган ам.доллар/

Зээлийн дугаар	Зээлийн төрөл	Зээлийн дүн	АХБ-наас татаж авсан дүн	Үүнд:		
				Хүү амлалтын шимтгэл	Ашигласан санхүүжилт	Төрийн сан дахь үлдэгдэл
L3787	Ердийн	\$19,000.0	\$707.0	\$707.0	-	-
L3788	Хөнгөлөлттэй	\$19,000.0	\$14,999.0	\$539.8	\$14,256.7	\$202.5
Нийт		\$38,000.0	\$15,706.0	\$1,246.8	\$14,256.7	\$202.5

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх L3787/3788-MON төслийн удирдлагын гарын авлагад АХБ-ны хөнгөлөлттэй 38.0 сая ам.долларын зээлийн хөрөнгийг ашиглах чиглэл, зарцуулах арга хэмжээний төрөл, зардлын тоо хэмжээг

хуваарилан баталсныг 2019-2025 оны эхний улирлын байдлаарх гүйцэтгэлийг нэгтгэн дүгнэхэд дараах байдалтай байна.

Доорх тооцоонд Монгол Улсын Засгийн газар татвараас чөлөөлөх замаар 0.4 сая ам.долларын татвар, хураамжийг санхүүжүүлэхээр төлөвлөснийг нэмж тооцсон болно.

Төслийн үйл ажиллагааны үр дүнгээр 19,278.3 мянган ам.долларын, 37,498.3 сая төгрөгийн гэрээ хэлцэл байгуулагдаж, урсгал үйл ажиллагааны зардал санхүүгийн тайланд бүртгэгдсэн байна.

Хүснэгт 3 /мянган ам.доллар, сая төгрөг/

№	Арга хэмжээний нэр төрөл	Төлөвлөсөн арга хэмжээ		Төслийн хэрэгжсэн арга хэмжээ		Олгосон санхүүжилт доллар төгрөг	Зөрүү	
		тоо	ам.доллар	тоо	Доллар, төгрөг		Арга хэмжээний зөрүү	Хүлээгдэж буй гүйцэтгэл санхүүжилт
	1	2	3	4	5	6	7=4-2	8=5-6
1	Барилга угсралтын ажил	6	\$27,425.0	8	\$ 18,031.5 ₮ 24,649.3	\$8,000.8 ₮10,754.0	2	\$10,030.7 ₮13,895.3
2	Бараа	2	\$138.0	4	₮ 835.1	₮ 815.2	2	₮20.0
4	Зөвлөх үйлчилгээ	6	\$1,961.0	11	₮ 8,082.5	₮ 4,628.6	5	₮3,453.8
5	Олон нийтийн оролцоотой худалдан авалт	1(15)	\$400.0	1(10)	₮ 1,191.9	₮ 562.4	1 (-5)	₮629.5
6	Төслийн үндсэн ажилтан	15	\$985.0	21	₮ 1,897.1	₮ 1,897.1	6	-
7	Төслийн нэгжийн зардал	-	\$200.0		₮ 842.3	₮ 842.3	-	-
8	Магадалшгүй ажлын зардал	-	\$5,010.0	-	-		-	-
9	Зээлийн хүү, хураамж	1	\$2,281.0	1	\$ 1,246.8	\$1,246.8	-	\$1,034.2
	Нийт дүн		\$38,400.0		\$19,278.3 ₮ 37,498.3	\$ 9,247.7 ₮19,499.7		\$11,064.9 ₮17,998.6

Төслийн удирдлагын гарын авлагад тусгагдсан ажлын гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

- Төслийн удирдлагын гарын авлагад барилга угсралтын 27,425.0 мянган ам.долларын 6 ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн хэдий ч гүйцэтгэлээр барилга угсралтын багц 18,031.5 мянган ам.долларын 2 ажил, 24,649.3 сая төгрөгийн 5 ажлыг хэрэгжүүлж эхэлсэн, 1,113.7 сая төгрөгийн 1 ажлыг эхлүүлээгүй ба төлөвлөснөөс 2 ажил зөрүүтэй байна.
- Төслийн удирдлагын гарын авлагад төслийн нэгжийн тавилга, тоног төхөөрөмж, хамгаалалтын захиргаанд эргүүлийн завь гэсэн 138.0 мянган ам.долларын 2 нэр

төрлийн бараа худалдан авах ажил төлөвлөсөн хэдий ч гүйцэтгэлээр Хог хаягдлын байгууламжид авто пүү, төслийн нэгжийн албан хэрэгцээнд автомашин худалдан авах 2 арга хэмжээ нэмж нийт 835.1 сая төгрөгийн 4 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

- Төслийн удирдлагын гарын авлагад захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний 1,961.0 мянган ам.долларын 6 ажил төлөвлөсөн. Гүйцэтгэлээр зөвлөх үйлчилгээний 8,082.5 сая төгрөгийн 11 ажлын гэрээ төлөвлөж, төлөвлөгөөг 5-аар нэмэгдүүлсэн байна. Үүнд:
 1. Хатгал тосгоны газар зохион байгуулалт, орон зайн төлөвлөлтийн зөвлөх үйлчилгээ 80.0 мянган ам.долларын төсөвтэй.
 2. Олон нийт, хэвлэл мэдээллийн зөвлөх үйлчилгээ 25.0 мянган ам.долларын төсөвтэй.
 3. ЧХАЖЦ-ын мэдээллийн төвийн барилгыг хяналтын зөвлөх үйлчилгээ 207.0 мянган ам.долларын төсөвтэй.
 4. Гүүгл платформд урлаг, соёлын өвийг хадгалах санг бий болгох зөвлөх үйлчилгээ /Хөвсгөл, Хэнтий/ 180.0 мянган ам.долларын төсөвтэй.
 5. Хөвсгөл дэд төслийн барилгын ажлын хяналтын зөвлөх үйлчилгээ 190.0 мянган ам.долларын төсөвтэй.
- Төслийн удирдлагын гарын авлагад олон нийтийн оролцоотой худалдан авах 400.0 мянган ам.долларын 1 багцын 15 арга хэмжээ төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 1,191.9 сая төгрөгийн 1 багцын 10 арга хэмжээ хийгдэж байна. Үлдсэн 5 арга хэмжээг хэрэгжүүлэх төсөвгүй болсон.
- Төслийн удирдлагын гарын авлагад төслийн нэгжийн бүтэц орон тоог үндсэн 10, техникийн 5 ажилтнаар баталж, 985.0 мянган ам.долларын төсөв баталсан, гүйцэтгэлээр үндсэн 10, техникийн 5, хувь зөвлөх 6 нийт 21 ажилтан ажиллуулж 1,897.1 сая төгрөг зарцуулсан байна.
- Магадалшгүй ажлын төсөвлөсөн 5.0 сая ам.долларын зардал гүйцэтгэлээр зарцуулагдаагүй байна.
- Зээлийн хүү хураамжийн зардалд 2.3 сая ам.долларыг төсөвлөж, гүйцэтгэлээр 1.2 сая ам.долларыг зарцуулсан байна.

1.2 Төслийн Удирдах хорооны тогтоолоор батлагдсан 2020-2024 оны худалдан авах ажиллагааны 5 төлөвлөгөөнд 24 арга хэмжээ батлагдаж, түүний хэрэгжилт 79.2 хувьтай биелсэн байна.

Төсөл хэрэгжиж буй 5 жилийн хугацаанд Төслийн Удирдах хорооны хуралдаанаар Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.10.8.2-т заасны дагуу жил бүр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

Төслийн нэгжийн тавилга, техник тоног төхөөрөмж, авто машин худалдан авах 2 бараа нийлүүлэх гэрээг төлөвлөгөөнд тусгаж батлаагүй байна.

Худалдан авах ажиллагааны 2020-2024 оны төлөвлөгөөнд 8 ажил, 3 бараа, 12 зөвлөх үйлчилгээ, олон нийтийн оролцоотой 1 худалдан авалт хийхээр 4 нэр

төрлийн 24 арга хэмжээг төлөвлөсөн байна. Тухайн жилийн ХАА-ны төлөвлөгөөнд батлагдсан боловч тендер шалгаруулалт амжилтгүй болсон арга хэмжээг дараа жил дахин төлөвлөх байдлаар ХАА-г зохион байгуулж иржээ.

Хүснэгт 4 (мянган ам.доллар)

Төслийн удирдах хорооны тогтоол	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө							
	Ажил		Бараа		Зөвлөх үйлчилгээ		Олон нийтийн оролцоотой	
	Тоо	Төсөв	Тоо	Төсөв	Тоо	Төсөв	Тоо	Төсөв
ТУХ-ны 2019 оны 01-р тогтоолын 2-р хавсралт	-	-	1	\$ 80.0	6	\$ 1,961.0	-	-
ТУХ-ны 2020 оны 02-р тогтоолын 3-р хавсралт	6	\$ 27,425.0	-	-	-	-	-	-
ТУХ-ны 2022 оны 05-р тогтоолын 2-р хавсралт	5	\$ 17,593.0	1	\$ 80.0	-	-	1	\$ 200.0
ТУХ-ны 2023 оны 07-р тогтоолын 3-р хавсралт	5	\$ 15,521.0	1	\$ 115.0	2	\$ 153.5	1	\$ 319.0
ТУХ-ны 2023 оны 08-р тогтоолын 3-р хавсралт	2	\$ 4,325.0	1	\$ 25.0	4	\$ 475.0	1	\$ 230.0
ДҮН	18	\$ 64,864.0	4	\$ 300.0	12	\$ 2,589.5	3	\$ 749.00

Төслийн нэгжийн худалдан авах ажиллагааны 2020-2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг нягтлан шалгахад 2021 онд төлөвлөгөөний биелэлт 17 хувьтай байгаа нь Ковид цар тахлаас шалтгаалсан, 2020 онд төлөвлөгөөний биелэлт 86 хувьтай байгаа нь хэрэгжилийн хувь бусад онтой харьцуулахад өндөр байна.

Нэгтгэсэн дүнгээр төсөл хэрэгжиж буй нийт хугацаанд 24 арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулж 19 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, 5 тендерийн шалгаруулалт амжилтгүй болсон тул Худалдан авах ажиллагааны хэрэгжилт 79.2 хувьтай гэж дүгнэв.

Хүснэгт 5
(мянган ам.доллар, сая төгрөг)

Үзүүлэлт	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт								Биелэлт /хувь/
	Ажил		Бараа		Зөвлөх үйлчилгээ		Олон нийтийн оролцоотой		
	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	
2020 он	-	-	-	-	6	6,242.4	-	-	86%
2021 он	1	\$10,531.50	-	-	-	-	-	-	17%
2022 он	2	9,040.5	1	223.08	-	-	1	279.1	57%
2023 он	1	\$ 7,499.99	1	399.99	1	1,198.2		270.0	44%
2024 он	2	15,608.8	-	-	1	641.9		642.8	50%
ДҮН	2	\$18,031.49	-	-	-	-	-	-	
	4	24,649.3	2	623.1	8	8,082.5	1	1,191.9	

Худалдан авах ажиллагааны тендер сонгон шалгаруулалтын дүнгээр нийт 18,031.5 мянган ам.долларын 2 гэрээ, нийт 34,546.7 сая төгрөгийн 17 багц гэрээг тендерт шалгарсан компаниудтай байгуулсан байна.

Худалдан авах ажиллагаанд илэрсэн асуудлууд:

- А1 буюу "Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа ба жуулчны мэдээллийн төвийн барилга угсралт"-ын багц 8 ажлын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвийн магадлалаар 6,727.5 сая төгрөгөөр баталгаажуулсан байхад уг ажлын тендерт НБИК ХХК-ийг 8,257.0 сая төгрөгийн үнийн саналаар шалгаруулж, хяналтын төсвөөс 1,529.5 сая төгрөгийн илүү дүнтэй гэрээ байгуулсан. Тус компанийн ирүүлсэн тендерт Жанхайн давааны ариун цэврийн байгууламжийн ажлын тоо хэмжээг огт тусгаагүй байхад тендерийг бүрэн хяналгүйгээр шалгаруулсан.
- А8 буюу Чингис хаан аялал жуулчлалын цогцолборын ажлын хяналтын төсөв 6,905.0 мянган ам.доллар байхад тендер сонгон шалгаруулалтаар "Мандалт констракшн" ХХК-ийг 7,500.0 мянган ам.долларын үнийн саналаар шалгаруулж, 595.0 мянган ам.долларын илүү дүнгээр гэрээ байгуулсан.
- А4 буюу Чингис хаан аялал жуулчлалын цогцолборын барилга угсралтын ажлын зураг төсөв өөрчлөгдсөн шалтгаанаар уг барилгын архитектурын зураг төсөл, хяналтын зөвлөх үйлчилгээ CS21 ажлыг хэрэгжүүлж байсан **Мон энерги ХХК-ний гэрээ хүчин төгөлдөр байхад**, шинээр А8 буюу "Чингис Хаан аялал жуулчлалын цогцолборын мэдээллийн төв болон бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөв, барилга угсралт, бараа нийлүүлэлт" гэсэн түлхүүр гардуулах гэрээний нөхцөлөөр тендерийг зарласан.
- Олон нийтийн оролцоотой худалдан авалтын тендерт гүйцэтгэгчээр шалгарсан Нарсан ой ХХК-ны үйл ажиллагааны үндсэн чиглэл зочид буудал, хүнсний барааны дэлгүүр, зоогийн газар гэж байхад явган зам, талбайн тохижилт барих барилга угсралтын ажлын гэрээ байгуулсан.
- Зөвлөх үйлчилгээний GS22, GS23, GS27 гэсэн 3 ажил, барилга угсралтын А7, бараа худалдан авах G4 гэсэн ажлуудын худалдан авах ажиллагааны үр дүн гараагүй, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй байна. Үүнд:
 - Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 25.0 мянган ам.долларын төсөвтэй.
 - Хатгал тосгоны газар зохион байгуулалт, орон зайн төлөвлөлтийн зөвлөх үйлчилгээ 80.0 мянган ам.долларын төсөвтэй.
 - Олон нийт, хэвлэл мэдээллийн зөвлөх үйлчилгээ 25.0 мянган ам.долларын төсөвтэй.
 - Гүүгл платформд урлаг, соёлын өвийг хадгалах санг бий болгох зөвлөх үйлчилгээ /Хөвсгөл, Хэнтий/ 180.0 мянган ам.долларын төсөвтэй.
 - Мөрөнгийн талбайн тохижилт, Ханх сумын төлбөр авах цэгийн барилга угсралт 547.0 мянган ам.долларын төсөвтэй.

1.3 Зөвлөх үйлчилгээний 4 гэрээний хугацаа хэтэрсэн, А2 ажлын гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааны хугацаа дууссан, CS17 зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг гэрээний заалтаас хэтрүүлэн олгосон.

Төслийн хэрэгжих хугацаанд захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан барилга угсралтын 6, бараа худалдан авах 2, зөвлөх үйлчилгээний 8, олон нийтийн оролцоотой худалдан авах 1 багц /10/ гэрээ тус бүрийн гүйцэтгэлийг холбогдох хууль, журамд нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийхэд дараах асуудал илэрсэн.

- Зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан хугацааг 30-аас 120 хоногоор хэтрүүлж, гэрээний холбогдох заалтыг зөрчсөн 4 ажил байна. Үүнд:
 - Эн Эй Пи Групп ХХК-ны хэрэгжүүлж буй “CS18 буюу Ариун цэврийн болон хатуу хог хаягдлын байгууламжийн инженерийн төсөвлөлт, хяналт”, “CS19 буюу ХНБЦГ-ын ХЗ, Мөрөн хотын талбайн архитектурын энгийн зураг төсөл, хяналт” 2 ажил 30-аас 55 хоног хэтэрсэн.
 - Хидро Инженеринг ХХК-ны хэрэгжүүлж буй “CS28 буюу Хөвсгөл дэд төслийн барилгын ажлын хяналтын зөвлөх үйлчилгээ”-ний ажил 70 хоног хугацаа хэтэрсэн.
 - Мон Энержи ХХК-ны хэрэгжүүлж буй “CS19 ЧХАЖЦ-ын архитектурын зураг төсөл, хяналт”-ын ажил 120 хоног хэтэрсэн.
- Бээжин Юни-Констракшн Групп ХХК-ны гүйцэтгэж буй А2 ажлын Голомт банкны 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 812FIPGA210009 дугаартай гүйцэтгэлийн баталгаа, мөн уг ажлын Голомт банкны 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 812FIPGA210007 дугаартай урьдчилгаа төлбөрийн баталгааны хугацаа тус тус 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдөр дууссан, гэрээний хугацаа сунгагдаагүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн “42.8.Төсвийн жил дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааны хугацаа дуусахаас өмнө захиалагчид гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлнэ”, “42.9. Гүйцэтгэгч энэ хуулийн 42.8-д заасан гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол түүнийг гэрээний үүргээ зөрчсөнд тооцож, гүйцэтгэлийн баталгааг захиалагчийн орлого болгоно” гэсэн заалтыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.
- CS17 буюу Хөвсгөл, Хэнтийн автозамын зураг төслийн хяналтын зөвлөх үйлчилгээний Эс Ар Пи Инженер Консалтинг Монголиа ХХК -нд Хэнтийн ажил эхлээгүй байхад, газар шорооны ажил 30 хувь хүрэхэд 10 хувийн санхүүжилт олгохоор заасан Гэрээний ерөнхий зүйлийн 41.2 дахь заалтыг зөрчин, зөвхөн Хөвсгөл дэх автозамын гүйцэтгэлийг үндэслэн 2,025.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Хэнтий аймаг дахь автозамын ажил эхлээгүй, Хөвсгөл аймаг дахь ажлын гүйцэтгэл 49 хувьтай байхад захиалагчийн хяналтын ажлын гүйцэтгэл 84.7 хувьд хүрч, Хэнтийн автозамын ажилд тавих төсөв дууссан.
- Хөвсгөл аймгийн автозамын гэрээт ажил хугацааны хоцрогдолтой байгаагаас шалтгаалж, CS17-г хэрэгжүүлэгч “Эс Ар Пи инженер консалтинг Монголиа ХХК” гэрээний дагуу санхүүжилтээ авахад хүндрэл үүссэн. Иймд “Эс Ар Пи инженер консалтинг Монголиа ХХК” 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/221 дугаартай албан бичгээр хүсэлт гаргасны дагуу 2020 оны 11 дүгээр сард байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулж 2024 оны 7 сараас Цаг хугацаанд суурилсан гэрээ (Time-Based Contract) болгон өөрчилсөн. Цаг хугацаанд суурилсан гэрээ болгон өөрчилснөөр 627.9 сая төгрөг өмнөх гэрээний үнийн дүнд нэмэгдэж гэрээнд 35,6%-ийн үнийн дүнтэй өөрчлөлт орсон байна.
- А8 буюу ЧХАЖЦ-ын мэдээллийн төв болон бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөв, барилга угсралт, бараа нийлүүлэлтийн ажлын зохиогчийн болон захиалагчийн хяналтад илэрсэн асуудлыг дор үзүүлээ.

Зохиогчийн хяналт:

Төслийн удирдлагын гарын авлагын Худалдан авах ажиллагааны **төлөвлөгөөнд тусгагдсан** CS21 буюу ЧХАЖЦ-ын архитектурын зураг төсөл, хяналтын 1,724.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зөвлөх үйлчилгээний тендерт Мон Энержи ХХК шалгарч, 2020 оны 12-р сард гэрээ байгуулан, зураг төслийн ажлаа гүйцэтгэж байсан тул **10%-ийн гүйцэтгэлд 172.5 сая төгрөгийн санхүүжилт** өгсөн. Энэ гэрээт ажил 2025 оны 01-р сарын 11-ний өдөр хүртэл **хүчин төгөлдөр байхад уг гэрээгээр гүйцэтгэх ажлыг А8 ажилд нэгтгэн шинээр дахин тендер зарлаж** Мандалт констракшн ХХК-тай 2022 оны 12-р сарын 26-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Улмаар Мандалт констракшн ХХК нь захиалагчийг төлөөлж зураг төсөл зохиогч Хатанбаатар ХХК-тай “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт гүйцэтгэх 02/24-3Х гэрээ”-г 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан байна.

Мон Энержи ХХК-ны гэрээ 2025 оны 1-р сарын 11-нд дуусгавар болсон ба гэрээний хэрэгжилт хангагдаж дуусаагүй байхад гэрээг хаахаар бэлтгэл ажлыг хангаж байгаа юм байна.

Гүйцэтгэгч “Мандалт констракшн ХХК”-ны туслан гүйцэтгэгчээр ажиллаж буй “Хатанбаатар ХХК” нь тус А8 ажлын зураг төслийн зохиогч бөгөөд **зохиогчийн хяналтыг** 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс хийж байна. Мөн Хатанбаатар ХХК нь санхүүжилтээ Мандалт констракшн ХХК-иар дамжуулан авч байгаа нь зохиогчийн хөндлөнгийн хяналт хийхэд сөрөг нөлөөлөл бий болох магадлалтай.

Монгол Улсын барилгын салбарын холбогдох хууль, дүрэм журмуудаар барилгын зураг төсөл зохиогч нь тухайн барилгын гүйцэтгэгч компанийн туслан гүйцэтгэгч байхыг шууд хориглосон заалт байдаггүй. Гэвч хариуцлагын давхардал үүсэх, хяналтын үр нөлөөг бууруулах, барилгын ажлын чанар, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

Дээрх тохиолдолд Төслийн нэгжээс А8 ажлын **захиалагчийн хяналтыг орон нутагт шилжүүлэх санал** гаргаж байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлэх бөгөөд зураг төсөл

Захиалагчийн хяналт:

Төслийн удирдлагын гарын авлагын Худалдан авах ажиллагааны **төлөвлөгөөнд тусгагдаагүй** CS25 буюу ЧХАЖЦ-ын мэдээллийн төвийн барилгын хяналтын зөвлөх үйлчилгээг **нэмэлтээр бий болгож** Эрчим төсөл ХХК-тай 1,198.2 сая төгрөгийн гэрээ хийж, эхний санхүүжилт 459.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон. А8 ажлын захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч CS25 Эрчим төсөл ХХК нь 2024 оны 4 дүгээр сараас 2024 оны 12 дугаар сар дуустал захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн ажлын хөлсөө аваагүй учраас 2025 онд А8 ажлын талбай дээр ажиллахгүй байна. Иймээс **А8 барилгын ажил нь захиалагчийн хяналтгүйгээр** үргэлжилж байна.

Энэ нь зураг төслийн шаардлага хангаагүй ажил гүйцэтгэх, норм, стандарт зөрчих; технологийн горим алдагдах; хяналтгүйгээр материалын илүүдэл, үргүй зардал гарах, төлөвлөгөөт хугацаа хэтрэх, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд маргаан үүсэх, гэрээний нөхцөл биелэгдэхгүйд хүрэх зэрэг **эрсдэлүүд үүсэх магадлалтай** байна.

Төслийн удирдлагын гарын авлагад тусгагдаагүй CS25 Эрчим төсөл ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ хийж, нийт гэрээний үнийн дүнгийн **38.4%-ийн санхүүжилтийг олгосон атал одоо тус гэрээг дуусгавар болгож** А8 барилгын гүйцэтгэгчийн захиалагчийн хяналтыг **орон нутагт шилжүүлэх санал гаргаж байгаа** нь төслийн удирдлагын гарын авлагаа мөрдөж ажиллахгүй байна.

зохиогч нь туслан гүйцэтгэгчээр ажиллаж буй энэ тохиолдолд барилгын ажлын захиалагчийн хяналтыг хөндлөнгийн, бие даасан байгууллагаар гүйцэтгүүлэх нь зохистой гэж үзэж байна.

1.4 Төслийн удирдлагын гарын авлагад заасан ажиллах хүчний хязгаарыг 125 хүн/сараар хэтрүүлэн 476.9 сая төгрөгийн илүү цалингийн зардал гаргасан байна.

Төслийн нэгжийн бүтэц орон тоог төслийн удирдлагын гарын авлагад төслийг удирдах 10, техникийн 5 албан тушаалтан байхаар тусгасан.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, бүрэлдэхүүнийг Сангийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 209 дүгээр тушаалаар анх 10 орон тоогоор баталж Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих үнэлэх журам”-ын дагуу ажилчдын цалинг Сангийн яамнаас тогтоосон байна.

Төсөл хэрэгжүүлж байгаа 2019 оноос 2025 оны 4 дүгээр сарын байдлаар 15 ажлын байранд 2,384.0 сая төгрөгийн цалингийн зардал бодогдсон. Төслийн удирдлагын гарын авлагад төсөл хэрэгжих хугацаанд 15 ажлын байранд 564 хүн/сар ажиллуулах төсөв баталсан бөгөөд үүний хэрэгжилтийг хянахад 125 хүн/сараар хэтрүүлж, 476.9 сая төгрөгийн цалин, хөлсний илүү зардал гаргасан байна.

Хүснэгт 6 /сая төгрөгөөр/

№	Төслийн нэгжийн ажилтан, техникийн ажилтны нэр	Ажиллах хугацаа	2025 оны 04 дүгээр сарын байдлаарх		Зөрүү /илүү, дутуу/	
			Ажилласан сар	Цалин хөлс	сар	Цалин хөлс
	Удирдах албаны нэгтгэл	456	581	2,013.0	125	476.9
1	Төслийн зохицуулагч	60	68	376.1	8	49.6
2	Хэнтий дэд төслийн менежер / Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан буюу дэд зохицуулагч	58	60	284.2	2	10.2
3	Хөвсгөл, дэд төслийн менежер / Нийгэм, жендер, иргэний нийгмийн мэргэжилтэн	50	65	279.0	15	77.0
4	Худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан	15	55	197.9	40	148.4
5	Санхүүгийн ажилтан	60	68	284.2	8	44.6
6	Олон нийттэй харилцах ажилтан / Захиргааны ажилтан	23	65	147.4	42	93.7
7	Байгаль орчны хамгааллын мэргэжилтэн	20	31	120.3	11	47.5
8	Хөвсгөл аймаг дахь ажилтан	55	52	104.8	-3	
9	Хэнтий аймаг дахь ажилтан	55	57	109.6	2	6.1
10	Жолооч	60	60	109.6	0	
	Техникийн ажилтнуудын нэгтгэл	108	103	371.0	-	
1	Эко-аялал жуулчлалын мэргэжилтэн	36	11	37.6	-25	
2	Авто замын инженер	20	46	152.7	26	

3	Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн мэргэжилтэн	20	20	86.4	0	
4	Тусгай хамгаалалттай газар нутгийн мэргэжилтэн	12	3	10.3	-9	
5	Барилгын инженер	20	23	84.1	3	
		564	684	2,384.0	125	476.9

Төслийн нэгжийн техникийн чиг үүрэг хэрэгжүүлэх 5 ажлын байранд авто замын инженер 26 сар, барилгын инженер 3 сарын илүү хугацаатай ажиллаж төлөвлөсөн хугацаанаас хэтрүүлэн цалингийн зардал гаргасан байна. Техникийн 5 ажлын байранд ажилласан ажилтнуудад 2025 оны 04 дүгээр сарын байдлаар 371.0 сая төгрөгийн цалин олгож, 2019-2023 онуудад нийгмийн даатгалын шимтгэл тооцож тайлагнаагүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн “7.2.3.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол ... гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, салбар, төлөөлөгчийн газар, төлөөний газарт ажиллаж байгаа ажилтан нийгмийн даатгалын төрөлд заавал хамрагдана” гэснийг хангаж ажиллаагүй байна.

Орон тоо хэтрүүлэн Төслийн удирдлагын гарын авлагад тусгагдаагүй 6 зөвлөхийг БОАЖЯ /хуучин нэрээр/-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар ажилд авч, хөлсөөр ажиллах **хувь зөвлөхийн** гэрээг 1-ээс 3 жилийн хугацаатай 537.7 сая төгрөгийн дүнгээр байгуулж, гүйцэтгэлээр 125.5 сая төгрөгийг олгосон байна. Зөвлөх үйлчилгээ худалдан авах гэрээний дүн 20.0 сая төгрөгөөс дээш бол ТБОНӨХБАҮХАТ хуулийн “31.1. Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын аль нэг аргын дагуу зохион байгуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Хүснэгт 7 /сая төгрөгөөр/

№	Албан тушаал	Албан тушаалтны нэр	Гэрээний хугацаа	Гэрээний дүн	Олгосон зардлын дүн	Зөрүү	Тайлбар
1	Ландфиллийн нөхөн сэргээлтийн зөвлөх	С.Аригуун	2022.10.05-2025.12.31	49.7	27.7	22.0	6 шилжүүлгээр 11 сарын гүйлгээ хийсэн
2	Монголын өв соёлын зөвлөх	С.Дулам	2022.08.18-2024.12.31	44.8	4.3	40.5	2 гүйлгээ хийгдсэн
3	Хуульч-хуулийн зөвлөх	Б.Хосжаргал	2025.01.20-2026.01.31	51.5	6.9	44.6	2 гүйлгээ хийгдсэн
4	Ус хангамж ариун цэврийн байгууламжийн зөвлөх	Б.Ганбат	2021.10.01-2024.12.31	112.7	38.0	74.7	10 шилжүүлгээр 11 сарын гүйлгээ хийсэн
5	Эко аялал жуулчлал менежментийн зөвлөх	Л.Байгаль	2025.01.22-2026.01.31	225.1	-		Цалин аваагүй
6	Худалдан авалтын гэрээт зөвлөх	Б.Цэнд-Аюуш	2022.08.10-2023.01.31	54.0	48.6	5.4	2 гүйлгээ хийгдсэн
Нийт дүн				537.7	125.5	187.1	

1.5 Зээлийн хөрөнгөөр бий болсон 223.1 сая төгрөгийн 2 ширхэг завийг орон нутгийн өмчид бүртгэсэн, 9,338.8 сая төгрөгийн үнэ бүхий 17 нэрийн 19 хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгүүлэх ажлыг бүрэн дуусгаагүй байна.

Төслийн нэгж нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад МОН3787/3788 зээлийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж болон тоног төхөөрөмжийг хүлээн авсан гүйцэтгэлийн дүнгээр санхүүгийн тайландаа Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан журмын 9.2.30-т заасны дагуу бүрэн бүртгэсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.4-т заасны дагуу “... тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана” гэсэн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Хэнтий, Хөвсгөл аймгийн ЗДТГ-т хөрөнгө шилжүүлэх ажил эхэлсэн байна.

Хүснэгт 8 /сая төгрөгөөр/

№	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
	Хөвсгөл аймгийн ЗДТГ-т	13		6,919.4
1	Хатгал тосгоны хатуу хог хаягдлын байгууламж	1	2,600.8	2,600.8
2	Ханх сумын хатуу хог хаягдлын байгууламж	1	1,243.7	1,243.7
3	Хатгал тосгоны бохир ус цэвэрлэх байгууламж	1	1,137.4	1,137.4
4	Ханх сумын бохир ус цэвэрлэх байгууламж	1	770.3	770.3
5	Хатгал, Ханх сумын автопүү	2	133.3	266.7
6	Юниверсал трактор	1	143.0	143.0
7	Юниверсал трактор	1	143.0	143.0
8	Бохир ус соруулах машин 10тн	1	185.0	185.0
9	Бохир ус соруулах машин 5 тн	1	85.5	85.5
10	Өөрөө буулгагч машин	2	163.0	326.0
11	Хатгал тосгоны Жанхайн давааны хяналтын камер	1	18.0	18.0
	Хэнтий аймгийн ЗДТГ-т	6		2,419.4
1	Дадал сумын хатуу хог хаягдлын байгууламж	1	1,874.6	1,874.6
2	Юниверсал трактор	1	143.0	143.0
3	Өөрөө буулгагч машин	1	163.0	163.0
4	Бохир ус соруулах машин 5 тн	1	85.5	85.5
5	Хог пресслэгч	1	19.9	19.9
6	Дадал сумын автопүү	1	133.3	133.3
НИЙТ				9,338.8

Хөвсгөл нуурын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд эргүүлийн 2 ширхэг завь нийлүүлэх 240.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендерт “Голден хоул” ХХК 223.1 сая төгрөгийн үнийн санал өгч гүйцэтгэгчээр шалгарч 22/261 тоот гэрээг 2022 оны 9 дүгээр сарын 28-нд байгуулж, БОАЖЯ-ны /хуучин нэрээр/ Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн А/244 тоот тушаалын хавсралтаар баталсан бүрэлдэхүүн завь хүлээн авах ажлыг зохион байгуулж гэрээний биелэлтийг 100 хувь буюу хангалттай зохион байгуулсан тул санхүүжилтийг 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр 23/02 дугаартай гэрээ дүгнэсэн акт үйлдэж санхүүжилтийг олгосон байна. Эргүүлийн 2 ширхэг завийг Хөвсгөл нуурын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 66 тоот албан бичгээр орон нутгийн өмчид бүртгэж авсан байна.

ДҮГНЭЛТ

1. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх L3787/3788-MON төслийн 38.0 сая ам.долларын зээлийн зарцуулалт, Зээлийн гэрээ, Төслийн удирдлагын гарын авлагад тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд Төслийн удирдлагын гарын авлага болон холбогдох хууль, тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллаагүй, зарим ажлыг батлагдсан төсвөөс илүү дүнгээр гэрээлсэн, гэрээний хугацаа хэтэрсэн, санхүүжилт илүү олгосон, зохиогчийн болон захиалагчийн хяналтыг сулруулсан, үр ашиггүй зардлууд гаргасан, төслийн гүйцэтгэл 42 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэлээ.

2. Төслийн удирдлагын гарын авлагад туссан 9 арга хэмжээнд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 32.2 сая ам.долларыг зарцуулж, 6.2 сая ам.долларын үлдэгдэлтэй ба төслийн удирдлагын гарын авлагад заасан арга хэмжээнээс зөрүүтэй 2 ажил, 2 бараа, 5 зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулсан байна.

3. Төслийн Удирдах хорооны тогтоолоор батлагдсан 2020-2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 79.2 хувьтай хэрэгжиж, 5 арга хэмжээний шалгаруулалт амжилтгүй болсон, зураг төсвийн магадлалаар баталгаажсан дүнгээс А1 ажлын гэрээг 1,529.5 сая төгрөгөөр илүү, А8 ажлын гэрээг 595.0 мянган ам.доллараар илүү гэрээлсэн, CS21 зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгч Мон энержи ХХК-ний гэрээ хүчин төгөлдөр байхад шинээр түлхүүр гардуулах гэрээ байгуулсан, үйл ажиллагааны үндсэн чиглэл нь тохирохгүй компанид барилгын тохижилтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгож ажил гүйцэтгүүлсэн зэрэг алдаа гарсан байна.

4. Зөвлөх үйлчилгээний 4 гэрээний хугацаа 30-аас 120 хоногоор хэтэрсэн, А2 ажлын гүйцэтгэгч Бээжин Юни-Констракшн Групп ХХК-ны гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааны хугацаа дууссанаас хойш 1 жил өнгөрч эрсдэл үүссэн, CS17 буюу Хөвсгөл, Хэнтийн автозамын зураг төслийн хяналтын зөвлөх үйлчилгээний Эс Ар Пи Инженер Консалтинг Монголиа ХХК-нд гэрээ зөрчиж илүү санхүүжилт олгосон, зөвлөх үйлчилгээний CS21-ийн гэрээ хүчинтэй байхад А8 ажлын багцад Хатанбаатар ХХК-ыг давхардуулан гэрээлсэн.

5. Төслийн нэгжийн ажилчдын ажиллах хугацааг 125 хүн/сараар хэтрүүлэн 476.9 сая төгрөгийн цалингийн илүү зардал гаргасан, хувь зөвлөх 6 ажилтныг БОАЖЯ-ны ТНБД-ын тушаалаар 537.7 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилд авч, 125.5 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан.

6. Зээлийн хөрөнгөөр бий болсон 223.1 сая төгрөгийн 2 ширхэг завийг орон нутгийн өмчид бүртгэсэн, 9,338.8 сая төгрөгийн үнэ бүхий 17 нэрийн 19 хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгүүлэх ажлыг бүрэн дуусгаагүй байна.

7. Гэрээний хугацаанд амжилттай хэрэгжсэн бараа нийлүүлэх 2, зөвлөх үйлчилгээний 2 ажил, олон нийтийн оролцоотой худалдан авалтын 1 багцын (10 аас 6 нь) ажил бүрэн дуусаж актаар хүлээн авсан байна.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Төслийг хэрэгжүүлэх явцад гарсан өөрчлөлтүүдийг Төслийн удирдлагын гарын авлагад тусган баталгаажуулах, Азийн хөгжлийн банкны хөндлөнгийн Мониторинг хийлгэж дүгнэлт гаргасны дараа төслийг албан ёсоор хүлээн авах саналтай байна.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---oOo---

